



МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА  
ХӨТӨЛБӨР

2024 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

# АГУУЛГА

01.

МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА ХӨТӨЛБӨР /1-2/

02.

ДОТООДЫН ХҮҮХЭД ИВЭЭН ТЭТГЭХ ХӨТӨЛБӨР /3-6/

03.

АЯН, КОМПАНИТ АЖЛУУД /7-8/

04.

ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА /9-18/

05.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ /19-20/



1

МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА  
ХӨТӨЛБӨР

# МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА ХӨТӨЛБӨР

Дэлхийн Зөн Монгол ОУБ нь 2018 оноос эхлэн Монголчууд Монголчууддаа хөтөлбөрийг хувийн хэвшил, орон нутгийн түншлэгчид, сайн дурынхны оролцоо, итгэл хүлээсэн ивээн тэтгэгчдийн тасралтгүй хандив, санхүүгийн дэмжлэгтэйгээр тусламж нэн шаардлагатай, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийг хамгаалах, тэдний оролцоо, хөгжилд хувь нэмэр оруулах, улмаар тэднийг өөртөө итгэлтэй, мөрөөдөлтэй бие хүн болон төлөвшиж, нийгмийн боломжийг тэгш хүртэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн.

## ХӨТӨЛБӨРИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД



### 1. ДОТООДЫН ХҮҮХЭД ИВЭЭН ТЭТГЭХ ХӨТӨЛБӨР

Ивээн тэтгэгч нь сар бүр нэг хүүхдийн 25,000 төгрөг хандивласнаар тухайн хүүхдийн хамгаалал, хөгжил оролцоонд хувь нэмэр оруулдаг.



### 2. ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хувийн хэвшлийн нийгмийн хариуцлага, Байгаль орчин, нийгэм, засаглалын стандартын хүрээнд тусгай төслүүдийг хэрэгжүүлж, Тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмрээ оруулдаг.



### 3. АЯН КОМПАНИТ АЖЛУУД

Жил бүр Сургуульд Бэлэн Аян, Дулаан Өвөлжье аянуудыг зохион байгуулж, Дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн хүүхдүүдэд шууд тусламж дэмжлэгүүдийг хүргэдэг.

## 2024 ОНД ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖСЭН БАЙРШИЛ



- 📍 Архангай
- 📍 Өвөрхангай
- 📍 Эрдэнэт
- 📍 Өмнөговь
- 📍 Сонгинохайрхан
- 📍 Хан-Уул



## 2 ДОТООДЫН ХҮҮХЭД ИВЭЭН ТЭТГЭХ ХӨТӨЛБӨР

# ДОТООДЫН ХҮҮХЭД ИВЭЭН ТЭТГЭХ ХӨТӨЛБӨР


Дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр нь итгэл хүлээсэн ивээн тэтгэгчдийн сар бүрийн нэг хүүхдэд өгдөг 25,000 төгрөгийн хандив тусламжаар хөтөлбөрийн хүүхдүүдийн хөгжил, оролцоог хангаж, гэр бүлийнх нь хамтаар чадваржуулан, хамгаалах зорилготой юм.

## 2024 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮНГҮҮД



Хүүхэд Хамгаалал

Нийт 756 эцэг эх, асран хамгаалагчдыг "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Гэр бүлийн баяр хөөр", "Аавын нөмөр" сургалтуудад хамруулж хүүхдэд ээлтэй, хамгаалагдсан орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.



Хүүхэд хөгжил

Орон нутгийн сургууль дээр суурилсан хөгжлийн клубүүдээр (Судлаач хүүхэд, Эко клуб, Үндэсний болон чөлөөт бүжиг, Үндэсний хөгжим, Гар бөмбөг, Бадминтон гэх мэт) дамжуулан нийт 501 хүүхдийг өөртөө итгэлтэй, хүсэл тэмүүлэлтэй бие хүн болгон чадваржуулсан.



Амьжиргаа Дэмжих

Нийт 23 өрхийн эцэг эх, асран хамгаалагчдыг "Өөрчлөлтийн төлөө хадгаламж" хөтөлбөрт хамруулж сар бүр тодорхой хуримтлал үүсгүүлэх замаар санхүүгийн зөв дадалд сургасан.



Хүүхэд Хяналт

Сайн дурын идэвхтэн, дэмжигчдийн оролцоотойгоор хөтөлбөрт бүртгэгдсэн 1,347 хүүхдэд улирал тутам хяналт тавьж, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлсэн.



Хамтын ажиллагаа

Хөтөлбөрийн үйл ажиллагааг тогтмол дэмжиж, идэвхийлэн оролцдог 1 хуримтлалын бүлгийн ахлагч, 12 гэрээр айлчлагч, 29 сайн дурын идэвхтэн тус тусын баг, хороогоо төлөөлөн хүүхдийн төлөө хариуцлагатайгаар хамтран ажилласан.



Эдийн засгийг бэхжүүлэх

Хөтөлбөрт хамрагдсан 9 өрхийн гишүүд оёдол эсгүүрийн сургалтад хамрагдаж ур чадвараа нэмэгдүүлсэн. Тэдгээрээс 6 суралцагч нэгдэн монгол хувцас захиалга, засварын үйлчилгээ эрхлэх тоног төхөөрөмжийн дэмжлэг авснаар нэмэлт орлого олж эхэлсэн.


## ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР

2024 оны 09-р сарын байдлаар 1,647 хүүхэд бүртгэлтэй байгаагийн 83% ивээн тэтгэгчтэй байна.



## ИВЭЭН ТЭТГЭГЧИД, ДЭМЖИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 09-р сарын байдлаар 1,065 ивээн тэтгэгч, дэмжигч бүртгэлтэй байна.



## НОМИН ХОЛДИНГИЙН 100 ХҮҮХЭД ИВЭЭН ТЭТГЭХ ТӨСӨЛ

### Зорилго:

- Дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт бүртгэлтэй 100 хүүхдийг сонгон ивээн тэтгэж улмаар тэднийг хөгжлийн дугуйлан клубуудад хамруулан, эцэг эх, асран хамгаалагчдыг нь чадавхжуулах мөн шууд тусламжуудыг хүргэх.

Хэрэгжих байршил: СХД

Хэрэгжих хугацаа: 2023-2025 оныг дуустал 3 жилийн хугацаанд

Төслийн үр шим хүртэгчид: 100 хүүхэд

Нийт төсөв: 1 жилийн 30 сая төгрөг

Уг төсөл нь дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт шинэ санал санаачилга болж чадсан бөгөөд нэг хүүхдийг нэг спонсортой холбох гэхээсээ илүү нэг байгууллагыг эсвэл хувь хүнийг хэд хэдэн тооны хүүхэдтэй холбох энэхүү групп спонсоршипийн аргачлалыг ашиглах нь илүү үр дүнтэй, үр ашигтай байх боломжийг бүрдүүлнэ гэж дүгнэсэн. Тиймээс цаашид ижил төрлийн төслүүдийг олноор хэрэгжүүлэхээр зорьж байна.





3

АЯН КОМПАНИТ АЖЛУУД

MORE  
JOY,  
AND  
JUSTICE  
FOR  
ALL  
CHILDREN.

# АЯН КОМПАНИТ АЖЛУУД

Монголчууд Монголчууддаа хөтөлбөрийн хүрээнд жил бүр зохион байгуулдаг Дулаан Өвөлжье, Сургуульд Бэлэн аянуудыг энэ жил амжилттай зохион байгуулж, дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн нийт 2,336 хүүхдэд шууд тусламж дэмжлэг болгон хүргэж чадсан.



## Дулаан Өвөлжье аян

Дулаан Өвөлжье 2024 аян нь бяцхан хүүхдүүдийг өвлийн гутал, дулаан хүрэм, хүнсний багц гэх мэт хамгийн хэрэгцээт зүйлсээр хангаж, тэднийг тэсгим өвлийн хүйтнийг эрүүл энх, дулаан давах, хичээлийн хоцрогдлоос сэргийлэх зорилготойгоор амжилттай зохион байгуулагдлаа. Тус аян нь 2024 оны 12-р сарын 1-ний өдрөөс 4-р сарын 12-ны өдөр хүртэл үргэлжилсэн ба аяны хүрээнд Дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн нийт 1,550 хүүхэд (748 эрэгтэй хүүхэд, 802 эмэгтэй хүүхэд) болон Архангай аймгийн 300 малчин өрхөд нийт 193.2 сая орчим төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Энэ жилийн хувьд хоёр жил дараалсан зудтай, хэрэгцээ шаардлага өндөртэй жил тохиосон нь хувийн хэвшил болон төрийн байгууллагууд олноор аянд нэгдэж орох үндэс болсон.



## Сургуульд Бэлэн аян

Хүүхэд бүрд өөрт байгаа авьяас чадвараа хөгжүүлж, сайн суралцахын тулд багш, анги танхим, ном, хичээлийн хэрэгслийн хүртээмжтэй байдал нэн чухал билээ. Иймд бид “Боломжоо хуваалцдаг найз байя” уриан дор Сургуульд Бэлэн 2024 аяныг долоо дахь жилдээ амжилттай зохион байгуулж Дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн хүүхдүүдэд хичээлийн хэрэгслээр туслан, тэдэнд суралцах боломжийг тэгш олгосон. Аян 2024 оны 8 дугаар сарын 1-ны өдрөөс 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал үргэлжилсэн ба Дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн нийт 786 хүүхдэд (401 эрэгтэй хүүхэд, 385 эмэгтэй хүүхэд) 71.6 сая орчим төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Энэ удаагийн аянаар дижитал маркетинг болон эвент маркетингийг хослуулан ашигласан нь онцлох үйл явдал болсон ба дижитал буюу онлайнаар 5 орчим сая төгрөгийн хандив мөн эвент арга хэмжээнүүдийн (UB Comedy, Fat Cat Jazz event, Kafka movie nights, Open Mic event) хүрээнд 10 орчим сая төгрөгийн хандивийг бүрдүүлж чадсан. Иймээс цаашид энэ төрлийн маркетингийн арга хэрэгслийг илүү өргөн цар хүрээнд ашиглах нь зүйтэй гэж дүгнэсэн..



# ХХАДА ХХК

ТЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ

М ХЭЛНИЙ  
ТӨСӨЛ

TH, 2024



Төгээх  
Хайр  
RAVA



4 ХУВИЙН ХЭВШЛИЙН  
ХАМТЫН АЖИЛЛАГАА

## ОЮУ ТОЛГОЙН ХУРДАСГУУР САН

### ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

**ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ:** 40% /одоо хэрэгжиж байгаа/

**Зорилго:**

- Иргэдийн санаачилга бүхий төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд техник, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой.

**Хэрэгжих байршил:** Өмнөговь аймгийн Ханбогд сум

**Хэрэгжих хугацаа:** 2024.06.26–2025.06.26

**Төслийн үр шим хүртэгчид:** Ханбогд сумын нийт 500 орчим иргэд

**Нийт төсөв:** 110 сая төгрөг



## ЭМ АЙ Ю ДЭЭД СУРГУУЛЬ

### ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

**ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ:** 40% /одоо хэрэгжиж байгаа/

**Зорилго:**

- 10 хүүхдийг дөрвөн жилийн хугацаанд Эм Ай Ю дээд сургуульд үнэ төлбөргүй сургаж, ирээдүйн үйлчлэгч удирдагчдыг бэлтгэх. (Тэтгэлэгт сургалтын төлбөр, өдрийн хоол, дотуур байрны төлбөр багтсан)

**Хэрэгжих байршил:** Дэлхийн Зөн Монгол ОУБ-н хөтөлбөрүүд

**Хэрэгжих хугацаа:** 2024.09.01–2029.06.30

**Төслийн үр шим хүртэгчид:** Нийт 10 оюутан, тэдгээрийн гэр бүл

**Нийт төсөв:** 330 орчим сая төгрөг



# МОБИКОМ КОРПОРАЦИ

## 1. СУРАГЧДЫН ЦАХИМ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ: 100%

Үр дүн:


- Дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн хамтран ажилладаг нийт 9 сургуулийн сурагчдыг цахим орчны зөв зохистой хэрэглээ сэдэвт сургалтаар дамжуулан чадавхжуулж, цахим орчны эрсдлээс урьдчилан сэргийлсэн.

Хэрэгжсэн байршил: СХД, Өвөрхангай, Архангай, Эрдэнэт

Хэрэгжсэн хугацаа: 2024.04.01-2025.10.20

Төслийн үр шим хүртэгчид: 9 сургуулийн нийт 1,000 орчим сурагчид

Нийт төсөв: 10 сая төгрөг



## 2. SMART EDUCATION MENTORSHIP PROGRAM

ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ: 20% /одоо хэрэгжиж байгаа/

Зорилго:

- Өсвөр үеийнхнийг хувь хүний хөгжлийн менторшип хөтөлбөрөөр дамжуулан өөрсдийн нөөц бололцоог тодорхойлж, мэргэжлийн чиг баримжаагаа олж улмаар ирээдүйн зорьсон зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

Хэрэгжих байршил: БЗД, ХУД, Багануур, Говь-Алтай, Баян-Өлгий, Сэлэнгэ

Хэрэгжих хугацаа: 2024.09.20-2025.04.30

Төслийн үр шим хүртэгчид: 10,11-р ангийн 50 менти, 10 ментор

Нийт төсөв: 30 орчим сая төгрөг

## ХАМТАРЧ АЖИЛЛАХ МЕНТОРУУД



**Ч.Ганжавхлан**

Эрхэлдэг ажил:  
"Лантуун дохио" ТББ-ыг санаачлан байгуулагч

Бизнес эрхлэгч, инфлюенсер төдийгүй "Боорцог ба сарнай", "Автуус ба амьдрал", "Хөл биш" номуудыг зохиогч.



**Г.Төмөрзаяа**

Эрхэлдэг ажил:  
"Нэст Эдүкэйшн" сургуулийн захирал

Физик, Компьютерийн технологич, "Хоёрон шар шуруу" сургалт, судалгааны төвийн үүсгэн байгуулагч.



**Р.Эрдэнэтулга**

Эрхэлдэг ажил:  
Самсунг корпорацийн Стратеги төлөвлөлтийн төслийн удирдагч

Wgon-ий Их сургуулийг эдийн засгийн мэргэжлээр төгсөж, Харвардын Их сургуулиас бизнесийн удирдлагын мастерын зэргээ авсан.



**А.Түмэн-Эрдэнэ**

Эрхэлдэг ажил:  
"Industrial light & magic" студийн ахлах модель бүтээгч

"Space Jam 2", "The Batman", "Mandalorian", "Transformers" зэрэг дэлхийн алдарт бүтээлүүд дээр ажилласан артист.



**Б.Ану**

Эрхэлдэг ажил:  
Мандал даатгал ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал

Fullbridge ХХК-ийн хамтран үүсгэн байгуулагч, АНУ-н Illinois их сургууль болон California их сургуульд мастерт сурсан.



**Э.Жавхлан**

Эрхэлдэг ажил:  
Tesla-н Дата инженер

Data summit арга хэмжээг санаачлагч.



**Н.Сарнай**

Эрхэлдэг ажил:  
Bridgestone Mining Solutions Australia-н Логистикийн мэргэжилтэн

Солонгос улсад Олон улсын худалдаа, маркетингийн чиглэлээр суралцаж, үргэлжлүүлэн Австрали улсад мастерт сурсан.



**З.Номун**

Эрхэлдэг ажил:  
L'Oréal группийн Контент менежер

Тайвань Улсын Фэн Чиа Их сургуульд Олон улсын бизнесийн удирдлага чиглэлээр тэтгэлэгтэй суралцаж, үргэлжлүүлэн Франц улсад мастерт сурсан.

## 1. ӨСВӨРИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ: 100%

Төслөөс бий болсон үр дүн:

- Өсвөр насны 40 сурагчид эко дугуйлан, Хустайн байгалийн цогцолборт газартай хамтарсан зуны кемпэд хамрагдаж, байгалийн нөөцийг хамгаалах ойлголт, мэдлэг үр чадвараа нэмэгдүүлж, улмаар үе тэнгийнхэн, эргэн тойрондоо эерэг дуурайлал үзүүлэх боломжтой болсон.

Хэрэгжсэн байршил: ХУД-ын Биокомбинатын 10-р сургууль

Хэрэгжсэн хугацаа: 2024.05.01-2025.07.31

Төслийн үр шим хүртэгчид: Сургуулийн ахлах ангийн 40 сурагчид

Нийт төсөв: 20 сая төгрөг

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗУРАГ



## 2. СУРГУУЛИЙН НОМЫН САН ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ: 100%

Төслөөс бий болсон үр дүн:

- Сургуулийн номын санг шинэчлэн засварлаж, номын клубээр дамжуулан сурагчдыг ном унших дадалд сургаж, суралцах идэвхийг нэмэгдүүлэн тэдэнд хичээлээс гадуурх цагаа зөв боловсон, бүтээлчээр өнгөрөөх боломжийг олгосон.

Хэрэгжсэн байршил: ХУД-ын Яармагийн 41-р сургууль

Хэрэгжсэн хугацаа: 2024.05.01-2024.06.30

Төслийн үр шим хүртэгчид: Сургуулийн нийт 1,000 сурагчид, 61 багш нар, номын санч

Нийт төсөв: 20 сая төгрөг

ӨМНӨ



ДАРАА



## 3. ЗУНЫ ЭКО КЛУБ

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ: 100%

Төслөөс бий болсон үр дүн:

- Өсвөр насны сурагчдыг зохистой хэрэглээ, хог хаягдлын менежмент болон хог хаягдлыг дахин боловсруулж гар урлалын бүтээгдэхүүн хийх мэдлэг, ур чадварт сургаж, бүтээлийн үзэсгэлэн гаргах боломжоор ханган, байгальд ээлтэй иргэн болж төлөвшихөд хувь нэмэр оруулсан.

Хэрэгжсэн байршил: ХУД-ын Яармагийн 60-р сургууль

Хэрэгжсэн хугацаа: 2024.06.07-2024.06.25

Төслийн үр шим хүртэгчид: Сургуулийн ахлах ангийн 100 сурагчид

Нийт төсөв: 15 сая төгрөг

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗУРАГ



## 3. ЗУНЫ АНГЛИ ХЭЛНИЙ ДУГУЙЛАН

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ: 100%

Төслөөс бий болсон үр дүн:

- Эм Ай Ю дээд сургуулийн Англи хэлний багшийн тэнхимийн гадаад багш нартай хамтран анхан болон дунд шатны англи хэлний эрчимжүүлсэн сургалтаар дамжуулан сурагчдыг зуны амралтаа үр бүтээлтэй өнгөрүүлж, англи хэлний мэдлэг үр чадвараа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлсэн мөн Англи хэлний багш нарийн заах арга зүйг нэмэгдүүлсэн.

Хэрэгжсэн байршил: ХУД-ын Нисэхийн 7-р сургууль

Хэрэгжсэн хугацаа: 2024.06.01-2024.07.31

Төслийн үр шим хүртэгчид: Сургуулийн 106 сурагч, Англи хэлний 10 багш

Нийт төсөв: 20 сая төгрөг

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗУРАГ



## 5. ӨСВӨРИЙН АВРАГЧ КЛУБ

**ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ:** 20% /одоо хэрэгжиж байгаа/

**Төслийн зорилго:**

- Өсвөрийн аврагч клубын аргачлалаар дамжуулан өсвөр насны охид хөвгүүд болзошгүй, гэнэтийн гамшиг ослоос өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх мэдлэг, дадлага ур чадвартай болж, аюулгүй амьдрах арга ухаанд суралцана.

**Хэрэгжих байршил:** ХУД-ын Шувуун Фабрикийн 26-р сургууль

**Хэрэгжих хугацаа:** 2024.09.15–2025.11.30

**Төслийн үр шим хүртэгчид:** Сургуулийн дунд, ахлах ангийн 400 сурагчид, багш ажилтнууд

**Нийт төсөв:** 25 сая төгрөг

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗУРАГ



## RED DAY - ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ

ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ: 100%

Үр дүн:

- Keller Williams үл хөдлөхийн компанитай хамтран нийт 150 өрхөд хүнсний тусламж, хүүхдийн боловсролын багцыг бэлэглэсэн нь өвлийн хүнд цаг үед өрх гэр бүлүүдэд томоохон дэмжлэг болж чадсан.

Хэрэгжсэн байршил: СХД

Хэрэгжсэн хугацаа: 2024.05.09

Төслийн үр шим хүртэгчид: Дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн 150 өрх

Нийт төсөв: 10 сая төгрөг



## ХҮҮХДИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЗӨВЛӨЛ - ОРОЛЦООТ ХӨГЖЬЕ КЛУБ

ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ: 30% /одоо хэрэгжиж байгаа/

Зорилго:

- Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Хүүхдийн өөрөө удирдах зөвлөлийн үе үеийн төгсөгч нар, хөтөлбөрийн үр шим хүтэгч залуусын төлөөлөл нэгдэж, Оролцоот хөгжье клубийг санхүүжүүлэн Дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн хүүхдүүдийг чадавхжуулахаар зорьсон.

Хэрэгжих байршил: СХД-ын 3 сургууль

Хэрэгжих хугацаа: 2024.09.20-2025.04.30

Төслийн үр шим хүртэгчид: Дунд ангийн 80 сурагчид

Нийт төсөв: 20 орчим сая төгрөг



## БУСАД ХАМТЫН АЖИЛЛАГАА

### АМЕРИКИЙН ХУДАЛДААНЫ ТАНХИМ


Хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2023 оны 12 дугаар сард Америкийн Худалдааны Танхимын (American Chamber of Commerce - Amcham) гишүүн байгууллагаар элсэн орсон. Тус байгууллага нь Монголын томоохон 100 орчим бизнесүүдийг гишүүнчлэлдээ нэгтгэсэн бизнесийн нетворкинг холбоо байгууллага юм. Бид Amcham болон Lorinet сантай хамтран нийт 20 орчим байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулсан Community Field Visit Day-г 2024 оны 6 дугаар сард амжилттай зохион байгууллаа. Тус айлчлалаар СХД-ын Эмэгтэйчүүдийн Төв дээр зочилж, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын төсөл, хөтөлбөрүүд нэн ялангуяа Амьжиргаа дэмжих, эдийн засгийн төсөл хөтөлбөрүүдийг танилцуулсан. Мөн сар бүрийн нетворкинг уулзалтуудад хамрагдаж хамтын ажиллагаа, харилцаа холбоогоо тэлж чадсан.



### МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим нь гишүүнчлэлдээ 5,000 гаруй үндэсний компани, бизнесүүдийг нэгтгэсэн, бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, холбогч, дэмжигч байгууллага юм. Бид 2023 оны сүүлээр тус байгууллагатай хамтын ажиллагаа эхлүүлсэн бөгөөд улирал тутам бизнесийн байгууллагуудын төлөөллүүдийн нэгдсэн нетворкинг уулзалтад оролцож, харилцаа холбоогоо тэлж чадсан.







# 5 САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

# САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Монголчууд Монголчууддаа хөтөлбөрийн хүрээнд бид 2024 оны санхүүгийн жилд хувийн хэвшлийн байгууллагууд, орон нутгийн түншлэгчид, итгэл хүлээсэн ивээн тэтгэгчдийн тасралтгүй дэмжлэгтэйгээр нийт 608,135,860 төгрөгийн бэлэн мөнгөний хандивийг бүрдүүлж чадсан. Үүнээс 34 хувийг нь Дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн 25,000 төгрөгийн хандив бүрдүүлсэн бол 30 орчим хувийг хувийн хэвшлийн хамтын ажиллагаанаас бүрдүүлж, 36 хувийг Дулаан өвөлжье болон Сургуульд бэлэн аяны хүрээнд бүрдүүлсэн байна.

## Орлогын төрлөөр /сая төгрөг/



A young girl with a joyful expression is wearing a red Santa hat with a white fur trim and a maroon coat. She is standing next to a light brown goat with curved horns, which has a blue bow tied around its neck. The background shows a rustic wooden structure with snow on the roof, suggesting a winter or high-altitude setting. The ground is dirt.

Монголчууд Монголчууддаа хөтөлбөрийг дэмжигч байгууллагууд, хувь хүмүүс, ивээн тэтгэгчид, сайн дурынхан болон ажилтнууддаа чин сэтгэлийн талархал илэрхийлье. Бид бүгдийн хүүхдийн сайн сайхны төлөөх хамтын ажиллагаа улам өргөжин тэлэх болтугай!